

Уулбаян сумын Засаг Даргын Тамгын Газрын
2023 оны 03 дугаар сарын үйл ажиллагааны тайлан
2023 оны 04 дугаар сарын 25-ны өдөр

Сургуулийн өмнөх байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр:

- Үндсэн сургалтад хамрагдсан багш нар амжилттай төгсөж сертификатаа авлаа.
- “Шувуухай-2023” наадмын удирдамж гарсны дагуу 5 төрөлд бэлтгэл хийгдэж байна.
- Байгууллагын болон багшийн ажлыг үнэлэх гүйцэтгэлийн үнэлгээ хийгдэж дууслаа. Үнэлгээнд нийт 5 бүлгийн 95 хүүхэд сонгогдсоноос хүндэтгэх шалгаантай 7 хүүхэд хамрагдсангүй. Мөн 88 эцэг эхийг санал асуулгад хамруулан ажиллалаа.
- ХАБ-ын сарын аяныг зохион байгуулж нийтдээ 25 ажлыг төлөвлөн ажиллаж байна.
- Эцэг эхчүүдийн дунд “Хоолны амталгаат өдөрлөг” зохион байгууллаа. 50 эцэг эхийг хамруулан ажиллалаа.
- Ажлын байрны дасгалыг Лхагва гариг бүрийн 7²⁰-аас хийж хэвшээд байна.

Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлээр:

- Тайванийн Хүүхэд Гэр бүлийг дэмжих санд бичсэн төсөл дэмжигдэж дотуур байрын сурагчдад 75 ширхэг гудас шинээр худалдан авлаа.
- Төсвийн шинэчлэлээр түүхийн дурсгалт газраар аялах, музей үзэхэд сурагчдад дэмжлэг үзүүлэх зардал төсөвт тусгагдсаны үр дүнд сургуулийн захиргаа, эцэг эхчүүд, багш нарын дэмжлэгээр нийт 10 бүлгийн 191 суралцагч анги хамт олноороо аяласан.
- Аймаг, сумын хүүхдийн VI чуулганд сурагчдын өмнө тулгамдаж буй 3 асуудлын нэг болох номын сангийн тохижилт, номын фондыг нэмэгдүүлэх санал хүсэлтийг шийдвэрлэж ОНХС-аас ЕБС-ийн номын санд 10 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ.
- СТЕМ боловсролын “Бүтээлч багачууд, шилдэг арга зүй” уралдааны нэгдүгээр шатыг зохион байгуулав.
- Түмэнцогнт сумын ЕБС-ийн удирдлагын баг, Заах аргын нэгдлийн ахлагч нарын хамт ирж нэг өдөр ажиллаж туршлага судлан, хамтран ажиллах гэрээ байгуулан, ажлын төлөвлөгөө гаргалаа
- Тус сургуулийн 1993 оны төгсөгч Ж.Батдулам, Д.Ган-Очир, Б.Лхагвасүрэн, Б.Отгонбаатар, А.Оюун-Эрдэнэ, Т.Сарантуяа, Ч.Эрдэнэтуяа, Ц.Эрдэнэчимэг нараас сургуулийнхаа номын санд "Дэлхийн хүүхдийн

шилмэл зохиол" цувралаас уншигч хүүхэд багачуудын маань эрэлт хэрэгцээтэй, уншихыг хүссэн 244000 төгрөгийн 33 ширхэг ном бэлэглэж номын сангийн фондыг баяжууллаа.

Соёлын төвийн үйл ажиллагааны чиглэлээр:

“ТАЛЫН ЭЗЭНТ ГҮРЭН ТӨСӨЛ”-ийн хүрээнд Чингис хааны музей, түүх археологийн хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж байгаа төслийн багийнхантай сумынхаа соёлын дурсгалт газруудаар явж шинээр 60 гаруй булшийг илэрүүлсэн.

3.2 Сүхбаатар аймгийн Баруун бүсийн сумдын Соёлын ажилчдын “УРЛАГТАЙ УУЛЗАЛТ 2023” нэгдсэн арга хэмжээнд өв соёлын наадаан тэмцээн болж 4 багийн 20 хүн оролцсон.

- мэндчилгээ
- түргэн хэллэг
- бөгцөг няслах
- таавар таах
- шагай шүүрэх гэсэн төрлүүдээр явагдсан.

Хүүхдийн бүжгийн дугуйлангийн нийт 54 хүүхдийн бүрэлдэхүүнтэй явагдаж байна.

-Цэцэрлэгийн 16 хүүхэд

-Сургуулийн 39 хүүхэд

4.2.Насанд хүрэгчдийн 16-тоот бүжгийн дугуйлан долоо хоног бүрийн Лхагва гарагт явагдаж байна.

Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр:

- Үзлэг бүгд- 1037
- Амбулаторын үзлэг- 667
- Урьдчилан сэргийлэх үзлэг – 149
- Идэвхитэй хяналт – 8
- Гэрийн дуудлага – 204
- Артерийн даралтын үзлэг – 60
- Чихрийн шижингийн үзлэг – 71
- Хөхний үзлэг – 58
- 0-2 насны 38 хүүхдийг товлотт дархлаажуулалтанд бүрэн хамруулсан байна.

ЕБС-ийн дотуур байрны сурагчид болон Натарцэцэг багштай 6Б анги, Ж. Мөнх-Од багштай 2Б анги, Д. Долмаа багштай 3Б анги, Э. Баасан багштай 1Б ангийн сурагчдад амны хөндийн эрүүл ахуй, шүдээ хэрхэн зөв угаах талаар сургалт хийсэн. Нийт 172 сурагч хамрагдсан.

➤ **Нийгмийн даатгалын чиглэлээр:**

Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 237087.5 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ.

Үүнээс:

- Ажил олгогчоос шимтгэлд -201883.1 мян төг
- Сайн дурын даатгалын шимтгэл- 22597.0 мян төг
- 0-3 насны эхийн шимтгэл-4545,9
- ЭМДаатгалын шимтгэл -8061.5 мян төг орлоо.

Сайн дурын даатгалд 100 даатгуулагч даатгуулснаас шинээр 5 малчин ажилгүй 2 даатгуулагчийг хамруулаад байна.

Тус хугацаанд тэтгэвэр тогтоолгох-7 тэтгэврээ өөрчлөн тогтоолгох- өргөдөл-2 , Банк солих-2, тэтгэмж-6, ажилгүйдлын тэтгэмж-0 , малчнаар ажилласан жилээ тогтоолгох -0 нийт 17 өргөдлийг хүлээн авч бүрэн шийдвэрлэж. 201 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргээд байна.

- Тэтгэвэрт - 477 тэтгэвэр авагчдад 944341.3 мян төгрөгний тэтгэвэр,
 - ХЧТА тэтгэмжинд- 3 даатгуулагчдад 257.8 мянган төгрөг,
 - Оршуулгын тэтгэмжинд- 4 тэтгэвэр авагчдад 8000,0 мян төгрөг,
 - Жирэмсэн амаржсаны тэтгэмжийг- 8 даатгуулагчдад 11560.0 мян төг,
- нийт 964159.1 мян төгрөгний тэтгэвэр, тэтгэмжийг сар бүр олгоод олголтын зөрчилгүй ажиллаж байна. Зарцуулагдаагүй сангийн үлдэгдлийг НДХэлтсийн ЭМДаатгалын санд- 20506.6 мян, ҮОШМӨ санд- 5455.7 мян, Ажилгүйдлын санд 1827.1 мян төгрөгийн шимтгэлийг сар бүр төвлөрүүлээд байна.

2022 оны нийгмийн даатгалын шимтгэлийн 64,6 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдууллаа.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

2023 оны 03 дугаар сарын 25-аас 04 дүгээр сарын 10-ны хүртэлх хугацаанд багийн дарга нартай хамтарч 2022 оны жилийн эцсийн мал тооллогоор тоологдсон 700 гаруй малтай өрхийн мэдээллийн тулгалтыг малын нэгдсэн системд тулган оруулах ажлыг гүйцэтгэсэн.

2023 оны 04 дүгээр сарын 14 –нд багийн дарга нартай хамт баян багийн сэг зэмийн устгалд оролцсон ба 30 бод 40 гаруй богд устгал хийж ариутгал хамтарч ажилласан.

“Шим” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу огтоно устгалын хордуулсан будааг татан авч малчдад тарааж өгөх ажлыг зохион байгуулж байна. Мөн

Сүхбаатар аймгийн ХХААГ-аас сумдад тарааж байгаа 2.8 тонн хордуулсан будааг татан авав.

Байгаль орчны чиглэлээр:

Нэгдсэн хогийг цэгцлэх, цуглуулсан сэг зэмийг булшлах ажлыг зохион байгуулав. Эм эл цахиурт овоо компаний техникийг нийгмийн хариуцлагын хүрээнд ашиглаж Нийт 16 га талбайд тархаад байсан энгийн хог хаягдал, малын сэг зэмийг ландфилын аргаар түрж тэгшлэх, тээвэрлэж нүхэнд хийж булшлах ажлыг зохион байгуулав. Үүнд 5,0 сая төгрөг зарцуулсан.

Мөн Байгаль хамгаалах сангаас хогний нэгдсэн төвд хяналтын камер 900,0 мянган төгрөгөөр авч суурилуулсан.